



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

7 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: БУА-2022/23/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Булган аймаг  
2022 он

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр

Утас:70342580 Цахим хаяг:ankhbayard@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас:70342716 Цахим хаяг:enkhtsoodolj@audit.gov.mn

Аудитор: Э.Одбаясах

Утас:99889486 Цахим хаяг: odbayasakhe@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **Агуулга**

---

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
3. Аудитын тайлан.....	14
3.1 Ерөнхий зүйл.....	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	15
3.4 Материаллаг байдал .....	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.8 Аудитын гол асуудал .....	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
4. Аудитын илрүүлэлт .....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	18

### **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

Аудитын санал дүгнэлт:



**БУЛГАН АЙМГИЙН  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082  
Утас/Факс:7034-3259  
E-mail:bulgan@audit.gov.mn

2022.02.25 № 119

танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

БУЛГАН СУМЫН ДОЛОО  
ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
Б.МЯГМАРЦЭНД ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны Булган сумын Долоо дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган сумын Долоо дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.


D:/bichighereg/2022A4toot

006020235

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>77,911,037.20</b>	<b>81,487,794.00</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	10,605,300.00	55,300.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	10,605,300.00	55,300.00
3351	Байгууллагаас авах авлага	10,605,300.00	55,300.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	66,597,994.20	81,432,494.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	-	56,840.00
35130	Эм боох материал	-	56,840.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	66,597,994.20	81,375,654.00
35410	Бичиг хэргийн материал	533,800.00	447,800.00
35420	Аж ахуйн материал	19,571,249.00	28,244,509.00
35430	Сэлбэг хэрэгсэл	3,003,076.20	11,990,054.00
35440	Түлш, шатах тослох материал	1,524,500.00	1,768,464.00
35450	Барилгын засварын материал	-	-
35460	Хүнсний материал	2,140,020.00	3,863,498.00
35470	Бусад хангамжийн материал	39,825,349.00	35,061,329.00
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	707,743.00	-
36600	Бусад нөөц	707,743.00	-
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>433,086,102.12</b>	<b>410,641,776.89</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	433,086,102.12	410,641,776.89
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	371,584,102.12	349,477,276.89
39201	Барилга, байгууламж, орон сууц	367,767,426.18	367,767,426.18
39202	Хуримтлагдсан элэгдэл	(31,732,671.54)	(53,104,710.90)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	35,207,840.00	36,418,640.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(10,248,408.54)	(14,949,142.53)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	19,434,464.00	23,291,464.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(9,246,347.98)	(10,712,874.90)
39214	Бусад үндсэн хөрөнгө	17,000.00	17,000.00

39215	Хуримтлагдсан элэгдэл	-	(8,499.96)
39217	Ном	384,800.00	757,975.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	61,502,000.00	61,164,500.00
39301	Програм хангамж	1,350,000.00	1,350,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(337,500.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	60,152,000.00	60,152,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>510,997,139.32</u></b>	<b><u>492,129,570.89</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>854,557.00</u></b>	<b><u>30,000.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	854,557.00	30,000.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	854,557.00	30,000.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	854,557.00	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	30,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>510,142,582.32</u></b>	<b><u>492,099,570.89</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	510,142,582.32	492,099,570.89
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	162,754,392.00	162,754,392.00
51101	Өмч: - төрийн	60,152,000.00	60,152,000.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(35,983,811.32)	(54,026,822.75)
51210	Өмнөх үеийн үр дүн	(35,983,811.32)	(35,983,811.32)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(18,043,011.43)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	383,372,001.64	383,372,001.64
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>510,997,139.32</u></b>	<b><u>492,129,570.89</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>545,770,280.00</b>	<b>532,403,493.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>11,684,480.00</b>	<b>2,391,493.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	11,684,480.00	60,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	11,684,480.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	11,684,480.00	-

7 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

120009	Бусад орлого	-	60,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		707,743.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		1,623,750.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>534,085,800.00</b>	<b>530,012,000.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	483,480,000.00	470,819,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	483,480,000.00	470,819,100.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	2,960,000.00
131103	ЗГНХ,ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	2,700,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	260,000.00
131106	Төсвийн урамшуулал		
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	50,605,800.00	56,232,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	50,605,800.00	56,232,900.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>539,613,795.68</b>	<b>549,975,936.40</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>539,613,795.68</b>	<b>549,975,936.40</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	469,121,405.07	516,596,017.17
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	319,519,073.40	347,726,422.84
210101	Үндсэн цалин	191,517,616.51	211,377,234.71
210102	Нэмэгдэл	90,729,275.73	95,580,308.41
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,286,695.55	7,877,500.00
210104	Урамшуулал	25,985,485.61	32,891,379.72
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	39,692,905.99	45,054,266.93
210201	Тэтгэврийн даатгал	27,385,267.25	31,594,316.82
210202	Тэтгэмжийн даатгал	3,203,267.01	3,440,972.46
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,741,570.09	2,822,504.60
210204	Ажилгүйдлийн даатгал	594,704.90	654,225.18
210205	Эрүүл мэндийн даатгал	5,768,096.74	6,542,247.87
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	49,210,331.00	52,226,230.00
210301	Гэрэл, цахилгаан	2,692,870.00	2,609,183.00

210302	Түлш, халаалт	44,613,181.00	48,416,793.00
210303	Цэвэр, бохир ус	1,904,280.00	1,200,254.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	7,222,159.00	13,133,382.20
210401	Бичиг хэрэг	1,601,800.00	1,973,380.00
210402	Тээвэр, шатахуун	511,250.00	2,673,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	467,707.00	447,820.00
210404	Ном, хэвлэл	116,000.00	18,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	267,000.00	892,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,099,600.00	241,550.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	365,700.00	-
210408	Бараа материал акталсны зардал	2,793,102.00	6,887,232.20
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	22,925,880.00	13,220,922.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	64,400.00	117,300.00
210502	Хоол, хүнс	21,456,380.00	11,387,952.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,405,100.00	1,715,670.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,471,000.00	11,587,550.00
210604	Урсгал засвар	1,471,000.00	11,587,550.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	271,000.00	484,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	55,000.00	484,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	216,000.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	28,809,055.68	33,162,843.20
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	600,000.00	787,743.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	460,800.00	250,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	27,748,255.68	32,124,300.20
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	70,492,390.61	33,379,919.23
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	630,000.00	3,300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	630,000.00	3,300,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	69,862,390.61	30,079,919.23

213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	69,862,390.61	30,079,919.23
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>6,156,484.32</u></b>	<b><u>(17,572,443.40)</u></b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	316,774.99	470,568.03
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	316,774.99	470,568.03
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	(316,774.99)	(470,568.03)
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>5,839,709.33</u></b>	<b><u>(18,043,011.43)</u></b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	162,754,392.00	383,372,001.64	(41,823,520.65)		504,302,872.99
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>162,754,392.00</b>	<b>383,372,001.64</b>	<b>(41,823,520.65)</b>	-	504,302,872.99
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	5,839,709.33		5,839,709.33
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	162,754,392.00	383,372,001.64	(35,983,811.32)	-	510,142,582.32
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	162,754,392.00	383,372,001.64	(35,983,811.32)	-	510,142,582.32
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>162,754,392.00</b>	<b>383,372,001.64</b>	<b>(35,983,811.32)</b>	-	510,142,582.32
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(18,043,011.43)		(18,043,011.43)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	162,754,392.00	383,372,001.64	(54,026,822.75)	-	492,099,570.89

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>537,965,550.00</u></b>	<b><u>530,072,000.00</u></b>

<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,879,750.00</b>	<b>60,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	3,879,750.00	60,000.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	29,700.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	29,700.00	-
120009	Бусад орлого	3,850,050.00	60,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>534,085,800.00</b>	<b>530,012,000.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	483,480,000.00	470,819,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	483,480,000.00	470,819,100.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	2,960,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	2,700,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	260,000.00
131106	Төсвийн урамшуулал		
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	50,605,800.00	56,232,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	50,605,800.00	56,232,900.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>529,466,050.00</b>	<b>520,629,200.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>529,466,050.00</b>	<b>520,629,200.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>458,877,659.39</b>	<b>487,299,280.77</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	317,292,954.40	348,050,348.98
210101	Үндсэн цалин	189,291,497.51	211,701,160.85
210102	Нэмэгдэл	90,729,275.73	95,580,308.41
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,286,695.55	7,877,500.00
210104	Урамшуулал	25,985,485.61	32,891,379.72
210105	Гэрээт ажлын хөлс		
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/		
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	39,692,928.99	45,584,897.79
210201	Тэтгэврийн даатгал	27,385,290.25	32,181,647.68
210202	Тэтгэмжийн даатгал	3,203,267.01	3,384,272.46
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,741,570.09	2,822,504.60
210204	Ажилгүйдлийн даатгал	594,704.90	654,225.18

210205	Эрүүл мэндийн даатгал	5,768,096.74	6,542,247.87
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	49,242,231.00	54,943,980.00
210301	Гэрэл, цахилгаан	2,692,870.00	2,609,183.00
210302	Түлш, халаалт	44,645,081.00	51,134,543.00
210303	Цэвэр, бохир ус	1,904,280.00	1,200,254.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	11,452,557.00	6,923,484.00
210401	Бичиг хэрэг	500,000.00	433,880.00
210402	Тээвэр, шатахуун	117,850.00	199,614.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	467,707.00	417,020.00
210404	Ном, хэвлэл	64,000.00	18,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,705,000.00	2,009,120.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,598,000.00	3,845,850.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	25,336,544.00	19,699,870.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	64,400.00	64,440.00
210502	Хоол, хүнс	21,162,944.00	13,081,430.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,109,200.00	6,554,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	999,600.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	999,600.00	1,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	271,000.00	584,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	55,000.00	584,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	216,000.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	14,589,844.00	10,512,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,751,400.00	8,907,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,838,444.00	1,605,100.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>70,588,390.61</b>	<b>33,329,919.23</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	726,000.00	3,250,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	726,000.00	3,250,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	69,862,390.61	30,079,919.23
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	69,862,390.61	30,079,919.23

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	8,499,500.00	9,442,800.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	8,499,500.00	9,442,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,499,500.00	9,442,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	8,499,500.00	9,442,800.00
222001	Тоног төхөөрөмж	8,499,500.00	9,436,800.00
223001	Бусад хөрөнгө	-	6,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(8,499,500.00)	(9,442,800.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(0.00)	(0.00)

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөг	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	0.00	527052000.00	496972080.77
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	0.00	527052000.00	487529280.77
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	0.00	526452000.00	486979280.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	0.00	371468000.00	348050348.98
210101	Үндсэн цалин	0.00	0.00	209890000.00	211701160.85
210102	Нэмэгдэл	0.00	0.00	107978000.00	95580308.41
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	0.00	11500000.00	7877500.00
210104	Урамшуулал	0.00	0.00	42100000.00	32891379.72
210105	Гэрээт ажлын хөлс				
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	0.00	51498200.00	45584897.79
210201	Тэтгэврийн даатгал	0.00	0.00	36319600.00	32181647.68
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	0.00	3848700.00	3384272.46
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	0.00	2981700.00	2822504.60
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	0.00	758900.00	654225.18
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	0.00	7589300.00	6542247.87
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	0.00	55232900.00	54943980.00
210301	Гэрэл, цахилгаан	0.00	0.00	2838000.00	2609183.00
210302	Түлш, халаалт	0.00	0.00	50164900.00	51134543.00
210303	Цэвэр, бохир ус	0.00	0.00	2230000.00	1200254.00

7 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210304	Байрны түрээс				
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	0.00	0.00	12906900.00	6603484.00
210401	Бичиг хэрэг	0.00	0.00	500000.00	373880.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	0.00	200000.00	199614.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	-	526,000.00	417,020.00
210404	Ном, хэвлэл	-	-	68,800.00	18,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	-	1,500,000.00	1,749,120.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	-	10,112,100.00	3,845,850.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал				
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	-	-	19,977,900.00	19,699,870.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	-	64,500.00	64,440.00
210502	Хоол, хүнс	-	-	13,358,000.00	13,081,430.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	-	6,555,400.00	6,554,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	-	4,000,000.00	1,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	-	3,000,000.00	-
210604	Урсгал засвар	-	-	1,000,000.00	1,000,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	-	-	90,900.00	-
210701	Гадаад албан томилолт				
210702	Дотоод албан томилолт	-	-	90,900.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	-	584,500.00	584,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	-	584,500.00	584,400.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	-	10,692,700.00	10,512,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-	9,087,400.00	8,907,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	-	1,605,300.00	1,605,100.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	-	600,000.00	550,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	-	600,000.00	550,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	-	600,000.00	550,000.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	-	-	<b>9,442,800.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	-	-	9,442,800.00
222001	Тоног төхөөрөмж	-	-	-	9,436,800.00
223001	Бусад хөрөнгө	-	-	-	6,000.00

	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	-	563,997,000.00	527,052,000.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	-	-	507,764,100.00	470,819,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	-	507,764,100.00	470,819,100.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих				
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	-	-	56,232,900.00	56,232,900.00
132001	Орон нутгийн төсвөөс	-	-	56,232,900.00	56,232,900.00
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	-	-	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	-	-	1.00	1.00
610002	Төсвөөс гадуур байгууллага				
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	-	-	30.00	30.00
620001	Удирдах ажилтан	-	-	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	-	-	18.00	18.00
620003	Үйлчлэх ажилтан	-	-	11.00	11.00
620004	Гэрээт ажилтан				
<b>63</b>	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	-	-	160.00	160.00
<b>631</b>	<b>СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА</b>	-	-	160.00	160.00
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	-	-	160.00	160.00
640003	Хувийн эмнэлгээр эмчлүүлэгсдийн тоо				
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	-	-	<b>30.00</b>	<b>27.00</b>
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	-	-	17.00	17.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	-	-	13.00	10.00
650010	Гэрээт ажилтан				

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>3,020,000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	<b>3,020,000.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	320,000.00
210304	Байрны түрээс		
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	320,000.00
210401	Бичиг хэрэг	-	60,000.00

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	260,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	2,700,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	2,700,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	2,700,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	2,960,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	2,960,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	2,700,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	260,000.00
131106	Төсвийн урамшуулал		
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (II)-(I)-(I)</b>		

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Булган аймгийн 7 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Э.Одбаясах гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

7 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Булган аймгийн 7 дугаар цэцэрлэг нь бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллагад дотоод аудитын нэгж, хариуцсан ажилтан ажилладаггүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Булган аймгийн 7 дугаар цэцэрлэг 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 539,930.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 5,399.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 3,779.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатанд дахин үнэлэж шинэчлэн тогтоогоогүй болно.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Булган аймгийн 7 дугаар цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 18,867.5 мянган төгрөгөөр буюу 3.7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлттэй гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	10,605.3	55.3	-10,550.3
Бараа материал	67,305.7	81,437.7	14,132.7
Үндсэн хөрөнгө	484,313.5	489,754.5	5,441.0
<b>Нийт хөрөнгө</b>	<b>562,224.5</b>	<b>571,247.5</b>	<b>9,023.0</b>

Өр төлбөр	854.5	30.0	-824.5
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	510,142.5	492,099.5	-18,043.0
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>510,997.1</b>	<b>492,129.5</b>	<b>-18,867.5</b>

Бараа материалын данс 81,432.4 мянган төгрөг болж 14,132.7 мянган төгрөгөөр өссөн нь 51,507.7 мянган төгрөгөөр орлого авч 29,786.0 мянган төгрөгний худалдан авалт хийж 6,887.2 мянган төгрөгийн бараа материал акталсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 489,754.5 мянган төгрөг болж 5,441.0 мянган төгрөгөөр өссөн нь өөрийн хөрөнгөөр бэлтгэсэн хөрөнгө, шилжүүлж авсан хөрөнгө хуучин ширээ сандал, хуучин номнууд акталсантай тус тус холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,154,990.9 мянган төгрөг болж 34,182.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

7 дугаар цэцэрлэг нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 743,578.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 743,578.6 мянган төгрөгөөр тооцож, төлөвлөн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Тус байгууллагаас хүргүүлсэн төсвийн төслийг 142,294.6 мянган төгрөгөөр бууруулан 601,284.0 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх сургуулийн өмнөх боловсрол олгох үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр 470,819.1 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээр, орон нутгийн төсвөөс 56,232.9 мянга нийт 527,052.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 496,972.0 мянган төгрөгийг зарцуулж, 30,080.0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 496,972.0 мянган төгрөг буюу 94.2 хувьтай байгаа нь ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 45,584.8 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 54,943.9 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 6,603.4 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн БСУГ-аас 260.0 мянган төгрөгийн ариутгалын зардал, 30.0 мянган төгрөгийн тендерийн баримт бичгийн үнэ, 2,700.0 мянган төгрөгийн аймгийн хэмжээнд

цэцэрлэгүүдийн дунд зохиосон уралдааны шагналын мөнгө нийт 2,950.0 мянган төгрөгийн санхүүжилтийг нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудит хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай дагуу хуулийн хугацаанд мэдээлсэн байна.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43-р тогтоол зүйлийн холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

#### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хэрэгжсэн байна.

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт	Биелэлт	Зөрүү
Хүүхдийн тоглоом худалдах, худалдан авахдаа гэрээний 1.3 дахь заалтыг хэрэгжүүлээгүй бараа бүтээгдэхүүнээ хугацаандаа аваагүйгээс, төсвийн шууд захирагч төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлээгүй авлага үүсгэсэн байна.	10.5	10.5	0
Е баримтаар худалдан авалт бүрийг хөөн шалгахад худалдан авалтыг цахим баримтаар баталгаажуулаагүй байна.	5.8	5.8	0

Бараа материалын ангиллыг буруу үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг бүртгэсэн байна.	0.7	0.7	0
Хүүхдийн тоглоом худалдах, худалдан авахдаа гэрээний 1.3 дахь заалтыг хэрэгжүүлээгүй бараа бүтээгдэхүүнээ хугацаандаа аваагүйгээс, төсвийн шууд захирагч төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлээгүй авлага үүсгэсэн байна.	10.5	10.5	0

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 360.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 360.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн байна.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад залруулсан алдаа байхгүй.

### 4.2 Төлбөрийн акт

Аудитын явцад төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

### 4.3 Албан шаардлага

Нэг удаагийн тэтгэмжээс багш ажилчид болох Ж.Оюундалай 135.0 төгрөгөөр, Б.Нандин-Эрдэнэ 180.0 төгрөгөөр, Б.Саранцэцэг 45.0 төгрөгөөр, тус тус шагнал урамшуулал олгосон нь ЗГ -ын 2021 оны "Төсвийн талаар авах арга хэмжээний тухай" 43-р тогтоолын 1.3 дахь заалтыг зөрчсөн.

Дээрх албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	7 дугаар цэцэрлэг	1	360.0					1	360.0		